

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2024 оны 04 дүгээр сарын тайлан
Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар**

2024.04.25

Шивээговь сум

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
ЗГ-ын тогтоол							
4	4	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	Өвөлжилтийн байдал хүндэрч малын зүй бус хорогдол их байгаатай холбоотойгоор төр-хувийн хэвшлийн байгууллагууд хамтран: Сумын төвийн Сэг зэм устгалын 2 цэгт нийт 8430 мал, амьтны сэг зэм, 21-р зөрлөгийн устгалын цэгт 2114 мал, амьтны сэг зэмийг булж устгаад байна. 2024 оны 04 дүгээр сард сумын хэмжээнд сэг зэм устгалын 5 цэг байгуулсан бөгөөд тус 5 цэгт сэг зэмийг цуглуулж булж устгах ажлыг хийж дуусгасан байна. Нийт сумын хэмжээнд хорогдсон малын 90 хувь буюу 14546 мал, амьтны сэг зэмийг булж устгаж, тус устгалын цэгүүдийг хашаажуулах, тэмдэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн зарим ажил үйлчилгээг хувийн байгууллагаар гүйцэтгүүлэх бодлогын хүрээнд “Шивээ-Овоо” ХК, “МАК” ХХК, “Српато” ХХК нар хамтран ажиллаад байна. Үр дүн: Хамтран ажилласан хувийн хэвшлийн байгууллагын тоо:3	100	ТЗУХ, ХБТХОХ	
11	17	Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай	7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг	“Цахим аймаг” арга хэмжээний хүрээнд сумын хэмжээнд цахимаар мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор “Шивээговь сум мэдээ” хаягаар 2024 оны 04 дүгээр сард нийт- 62 мэдээлэл цацагдсанаас шинээр-29, бусад байгууллагын-33	100	ТЗУХ	

		2023-02-08 Дугаар 2023_68	цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	мэдээлэлийг байршуулсан байна. Мөн веб сайтад 4 дүгээр сард нийт-38 мэдээлэл байршуулсан. Үүнд: цаг үеийн мэдээ-8, Тендерийн-4 зар, Суманд хийж хэрэгжүүлсэн 14 хоногийн мэдээ-3, сарын мэдээ-1, ОНХС-тай холбоотой-7 мэдээлэл, Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой-7 мэдээлэл, Засаг даргын А/33-А/40 хүртэх захирамжийг тус тус байршуулсан. 2024 оны 04 дүгээр сард сумын цахим хуудасны нийт дагагчийн тоон үзүүлэлт 4369 болсон байна. Сумын хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол оруулан ажиллаж байна. Үр дүн: 2024 оны 04 дүгээр сарын байдлаар “ХУР ДАН” системээр иргэдэд үйлчилгээ үзүүлсэн тоо:103			
25	33	Улсын нөөцөөс бараа материал гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай 2023-12-13 Дугаар 2023_449	З.. 3.Улсын нөөцөөс олгох тэжээлийг оновчтой хуваарилах, зориулалтын бусаар зарцуулах, худалдаалахаас урьдчилан сэргийлж, хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт 2024 оны I улиралд багтаан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	“Малчдад туслъя” аяны хүрээнд 04 дүгээр сарын 25-ны байдлаар хийгдсэн ажлуудаас дурдвал: <ul style="list-style-type: none"> ✚ 2024 оны 04 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Улсын онцгой комиссоос Аймгийн онцгой комиссын тэжээл цэгт төвлөрсөн тэжээлийн будаанаас суманд хуваарилагдсан 1 вагон малын тэжээлийн будааг шуудайлж савлах ажлыг зохион байгуулж, сумын малчин болон мал бүхий иргэдэд тараах ажил хийгдсэн. Тусламжийн будааг 98 малчин өрх, 33 мал бүхий өрх нийт-131 малчдад 356 шуудайг олгоод байна. ✚ “Малчдад туслъя” аяны хүрээнд 04 дүгээр сарын 19-ний өдөр “Каритас Монгол” ТББ-аас зорилтот бүлгийн 20 өрхөд тусламж үзүүлж 1 өрхөд 3 шуудай хивэг, 1 шуудай хорголжин тэжээл, 10кг-ын савлагаатай гурил 1 ширхэг, 5 кг-ын савлагаатай цагаан будаа 1 ширхэг, 2 кг савлагаатай элсэн чихэр 1 ширхэг, 2 кг салагаатай төл малын хуурай сүү 1 ширхэг, 1 кг савлагаатай малын глюкоз 1 ширхэг, 2 ширхэг угж, 2 ширхэг ажлын бээлийнээс бүрдэх багцыг Аймгийн аюулгүйн 	100	ТЗУХ	

				<p>нөөцийн агуулахаас малчдад гардуулан олгосон.</p> <p>Үр дүн: Зохион байгуулсан арга хэмжээний тоо: 2 Нийт тусламж авсан малчдын тоо: давхардсан тоогоор 254</p>			
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
34	46	<p>2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28</p>	<p>XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.</p>	<p>Сумын хэмжээнд нийт тоон гарын үсэг авах 16-91 насны 2405 иргэн байгаа бөгөөд үүнээс 2022 онд 1275 иргэн, 2023 онд 167 иргэн, 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 63, нийт 1505 иргэн бүртгүүлж тоон гарын үсгээ аваад байна.</p> <p>Үр дүн: Нийт тоон гарын үсэг авах иргэдийн 62.0 хувь нь тоон гарын үсэг буюу цахим гарын үсэгтэй болсон байна.</p>	70	ХЭЗХ, ТЗУХ	

37	49	2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2022-10-10 Дугаар 2022_49	XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав.	Байгууллагын мэдээллийн систем буюу http://shiveegovi.gs.gov.mn/ вебсайт нь “Үндэсний дата төв”-д холбогдсон тул Үүлэн системд давхар хянагдаж явдаг болно. Үр дүн: Байгууллагын мэдээллийн систем нь “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршсан байна.	100	ТЗУХ	
	52		XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	Төрийн үйл ажиллагааны дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлж, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж байна. Мөн Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэн, төрийн байгууллагуудын дотоод удирдлагын ERP системийг 2023 оны 10 сард Засаг даргын Тамгын газрын нийт 19 албан хаагчдад нэвтрүүлснээр баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөл бүрдсэн. Сумын хэмжээнд ERP системийг төрийн 3 байгууллага үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна. Үр дүн: Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP-д 2024 оны 04 дүгээр сарын 25-ны байдлаар ирсэн албан бичиг 154, явсан албан бичиг 56 байна.	100	ТЗУХ, ХЭЗХ	
42	55	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл	XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн	Манай байгууллагаас Үндэсний судалгааны нэгдсэн сан болох www.sudalгаа.gov.mn цахим платформд байршуулах 2024 оны 04 дүгээр сарын байдлаар	-	ТЗУХ, ХБТХОХ	

		2023-02-01 Дугаар 2023_6	системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	төрийн байгууллагын захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил байхгүй болно.			
48	62	2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18	XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Улсын онцгой байдлын ерөнхий газар болон аймгийн Онцгой байдлын газрын Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг сумын “Шивээговь сум мэдээ” цахим хаягаар анхааруулга, сэрэмжлүүлэгийг олон нийтэд тогтмол мэдээллэн хүргэж ажиллаж байна. Үр дүн: 04 дүгээр сарын байдлаар Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх 4 мэдээллийг иргэдэд хүргэсэн байна.	100	ТЗУХ, ХБТХОХ	
51	65	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу сумын хэмээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн 6 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. Үр дүн: 2024 оны 04 дүгээр сарын Шилэн дансны мэдээ оруулалтын байдал 100 хувьтай, 04-р сарын	100	ТЗУХ	

			хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.	тухай бүрт байршуулвал зохих 114 мэдээллийг ил тод мэдээллэсэн байна.			
56	78	2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 41 дүгээр тэмдэглэл 2023-10-11 Дугаар 2023_41	XVII.1. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хаврын мод, бут тариалахад бэлтгэх зорилгоор АБ, ААН, иргэд мод, бут тарих талбайгаа цэвэрлэх, хашааны хог хаягдал, элс шороог авах ажлыг зохион байгуулсан. Нийт 30 АБ, ААН-ийн 108 албан хаагч оролцсон бөгөөд 3 тонн хог хаягдал, 5 тонн элс шороог цэвэрлэж зөөсөн бөгөөд хог тээврийн машинаар зөөвөрлөж, сумын төв хогийн цэгт буулгасан байна. Үр дүн: Хамрагдсан нийт иргэдийн тоо: 108	100	ХБТХОХ, ТЗУХ	

				Зохион байгуулсан арга хэмжээний тоо:1			
58	80	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл 2023-12-06 Дугаар 2023_49	XIII.2. Зарим аймагт өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт үүрэг болгов.”	Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан эрсдэлийг бууруулах зорилгоор сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/171 тоот захирамжаар 38 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдож, сумын хэмжээнд “Онцгой байдлын штаб”-ыг томилгоожуулан, хуваарийн дагуу бэлэн байдлыг ханган 08:00-18:00 цаг хүртэл ажиллаж байсан бөгөөд Улсын Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн шийдвэр, Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/75 дугаар захирамжаар сумын шуурхай штабыг 24 цагаар томилгоожуулан, ажиллаж байна. Үр дүн: Сумын мэргэжлийн ангийн 64 гишүүн хуваарийн дагуу сумын Онцгой штабын жижүүрээр ажиллаж байна. Сумын онцгой байдлын төлөвлөгөөг 15 арга хэмжээтэйгээр төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилт 98.2 хувьтай хэрэгжээд байна	100	ТЗУХ, ХБТХОХ	
	84	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл 2023-12-20 Дугаар 2023_51	XXV.3.2.5. Хог хаягдлаас үүсэж буй байгаль орчны бохирдол, доройтол нь агаар, хөрс, усны бохирдлыг ихээр үүсгэж байгаатай холбогдуулан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	“Хоггүй сум” арга хэмжээний хүрээнд: <ul style="list-style-type: none"> ✚ Сумын төсвийн 5 албан байгууллага “Хог хаягдлын менежмент”-ийн төлөвлөгөөг гарган, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. ✚ Байгууллага бүр өөрийн хариуцсан нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээг өдөр бүр хийлгэх ажилтанг гэрээлж, сар бүр 50 мянган төгрөгөөр урамшуулж байна. Мөн 7 хоног бүр 50м хүртэлх гадна талбайн хог хаягдлыг цэвэрлэдэг. ✚ “Хоггүй сум” арга хэмжээний хүрээнд сумын хэмжээний бүх төвлөрсөн хогийн пункер, хог хаях хашаа зэргийг буулгаж, зөвхөн хуваарийн дагуу хогны машинд ачиж хаях ажлыг хэрэгжүүлээд байна. Ингэснээр 	100	ХБТХОХ, сумд	

				<p>нийтийн эзэмшил болон сумын төвд задгай хог 80-аас 90%-аар буурсан.</p> <ul style="list-style-type: none"> ✚ Хог хаягдлын хураамжийг бүрдүүлэх ажлын хүрээнд сумын “Шивээговь сум мэдээ” цахим хаягаар олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэхээр зар, контент байрлуулж ажиллаж байна. ✚ Сумын хэмжээнд өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотой мал, амьтны зүй бус хорогдол их байсан тул сэг зэм цуглуулах, устгаж булшлах ажлыг 04 дүгээр сарын 23-ныг дуустал зохион байгуулж ажилласан. Үүнд булаг шандны эх, бусад худаг уст цэгүүд, хаялага нуурын ойр орчмын мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулах ажлууд хийгдсэн байна. ✚ 2024 оны 04 дүгээр сарын байдлаар нийт 45 тонн хог хаягдлыг ачиж тээвэрлэн төв хогийн цэгт булшлаад байна. <p>Үр дүн: Сарын төлөвлөгөөний хэрэгжилт-100% тай хэрэгжиж байна.</p>			
ЗГ-ын албан даалгавар							
62	89	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6	1. 1.1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ	<p>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд 2024 оны 04-р сарын байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> ✚ ЕБС-ийн бага ангийн багшаар шилжиж ирсэн багшид 6 сарын байрны түрээсийг ЗДТГ-аас хариуцан, хамтран ажилласан. ✚ Мөн Бага ангийн 2 мэргэжлийн багшийг шинээр авч ажиллуулан түрээсийн зардлыг сургалтын байгууллага өөрийн зардлаар хариуцан ажиллаж байна. 	100	ХЭЗХ, ТЗУХ, ХБТХОХ	

			сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах;	Үр дүн: Орон сууцны түрээсийн дэмжлэг үзүүлсэн багшийн тоо-3			
93	“Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023-04-17 Дугаар 2023_01	1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажлын хүрээнд сумын албан ёсны вэб сайтыг нэгдүгээр улиралд багтаан шинэчлэх ажлыг төлөвлөн, тус ажлыг эрчимжүүлэн вэб сайтаа шинэчлэх ажил хийгдэн мэдээ мэдээллийг цаг тухай бүр байршуулан мэдээллийг шуурхай, хариуцлагатай, хүргэн ажиллаж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан заалтын дагуу мэдээллүүдээ тухай бүр шинэчлэн холбогдох мэдээллүүдийг байршуулан ажиллаж байна. http://www.shiveegovi.gs.gov.mn/ Үр дүн: 04 дүгээр сарын байдлаар веб сайтад нийт-38 мэдээлэл байршуулсан. Үүнд: цаг үеийн мэдээ-8, Тендерийн-4 зар, Суманд хийж хэрэгжүүлсэн 14 хоногийн мэдээ-3, сарын мэдээ-1, ОНХС-тай холбоотой-7 мэдээлэл, Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой-7 мэдээлэл, Засаг даргын А/33-А/40 хүртэлх захирамжийг тус тус байршуулсан байна.	100	ТЗУХ		
Дундаж биелэлт							98.7

			Бүгд	Үүнээс		
				Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар
Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо			13	3	8	2
Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо			14	3	9	2
Хэрэгжилтийн үнэлгээ	Бүрэн хэрэгжсэн	100%	12	3	7	2
	Хэрэгжих шатанд	70 %	1	-	1	-
	Хэрэгжилт хангалтгүй	30 %	-	-	-	-
	Хэрэгжээгүй	0 %	-	-	-	-
Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй			1	-	-	-
Биелэлтийн хувь			98.7	100	96.25	100

ХЯНАСАН:

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

М.ГАНТУЯА